



# ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

---

2020 оны 7-р сарын 16-аас  
23-ны байдлаар

---

## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 7-р сарын 16-аас 7-р сарын 23-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 19 дэх дугаарыг хүргэж байна.

### 1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- **ОХУ-ын эдийн засаг 2020 оны эхний хагаст 4.2 хувиар агшсан** гэж тус улсын Эдийн засгийн сайд Максим Решетников 7-р сарын 22-ны мэдэгджээ. Мөн эдийн засгийн сайд тус улсын эдийн засаг 2020 онд 4.8 хувиар агших хүлээлттэй гэж мэдэгдлээ.
- **АНУ-ын орон сууцны зах зээлд сэргэх хандлага ажиглагдаж эхэллээ.** АНУ-ын засгийн газраас мэдэгдсэнээр 2020 оны 6-р сард орон сууцны зах зээл хямралын өмнөх үеийн түвшинд тун ойртож ирээд байна. Орон сууцны зах зээл 5-аас 6-р сарын хооронд зүүн хойд хэсэгт хамгийн ихээр буюу 114 хувиар өссөн бол баруун эрэгт хамгийн багаар буюу 7.5 хувиар өссөн үзүүлэлттэй гарсныг “Үндэсний Орон Сууц Барилагчдын Холбоо” мэдэгдлээ. Үүний гол шалтгаан нь орон сууцны барьцаат зээлийн хүү бага байгаатай холбоотой юм. Тодруулбал, 30 жилийн хугацаатай тогтмол барьцаат зээлийн дундаж хүү 3 хүртэлх хувьд хүрч буураад байна. Түүнчлэн, гэрээсээ ажиллагсдын тоо нэмэгдсэн, зарим компаниуд цаашид ч гэрээсээ ажиллах боломжтой хүмүүсийн талаар судалж эхлээд байгаа нь хүмүүсийн илүү тухтай, том гэр хайх шалтгаан болж байгаа юм байна.
- “Deloitte Touché Tohmatsu Limited” компанийн эдийн засагч Майкл Вольф цар тахлын улмаас **хөгжиж буй орнууд хэд хэдэн томоохон хүндрэлтэй тулгараад байгааг** онцоллоо. Тухайлбал, гадаад эрэлт буурах, гадаад шууд хөрөнгө оруулалт тасалдах, багцын хөрөнгө оруулалтын гарах урсгал нэмэгдэх зэрэг дээр нэг том бэрхшээл нэмэгдээд байгаа нь гадаадад ажиллагсдын гэртээ илгээх мөнгө, мөнгөн гуйвуулга огцом буураад байна. Хөгжиж буй эдийн засагтай орнуудын 2019 оны урсгал шилжүүлэг нийтдээ 554 тэрбум ам.доллар байсан байна. Дэлхийн банкны тооцож буйгаар энэ дүн 2020 онд 20 хувиар буурах хүлээлттэй байна. Жижиг эдийн засагтай орнуудын хувьд энэхүү урсгал шилжүүлэг нь эдийн засагт ихээхэн нөлөө үзүүлдэг бөгөөд 20 хувиар буурах нь зарим ядуу буурай орнуудын хувьд томоохон хүндрэл үүсгэх юм.

#### Эх сурвалж:

1. Reuters, [Russia's economy contracted 4.2% in first half 2020: Ifax cites economy minister](#)
2. Deloitte, [Weekly global economic update July 20, 2020](#)
3. Continuum Economics, [Bank of Japan on Hold, Expects Moderate Recovery in H2](#)

## 2 БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **БНХАУ-ын эдийн засаг 2020 онд 2.5 хувиар өсөх төлөвтэй байна.** UBS группээс БНХАУ-ын эдийн засаг энэ онд 1.5 хувиар өсөхөөр төсөөлж байсан бол 2.5 хувь болгож төсөөллийг нэмэгдүүллээ. Төсөөллийг сайжруулахад дотоодын хэрэглээ, хөрөнгө оруулалт сэргэж, эдийн засгийн өсөлт хүлээлтээс даван 2-р улиралд 3.2 хувиар өссөн нь нөлөөлөв. Цар тахал дахин дэгдэх эрсдэл, АНУ, БНХАУ хоорондын худалдааны зөрчилдөөн хурцдаж байгаа байдал, нийлүүлэлтийн гинжин сүлжээ доголдох, ААН-ийн ашигт ажиллагаа буурсан зэрэг нь хөрөнгө оруулагчдын итгэлд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Гэхдээ макро эдийн засгийн бодлого оны сүүлийн хагаст өсөлтийг тэтгэх хүлээлттэй байгаа аж. Oxford economics байгууллага мөн 2-р улирлын гүйцэтгэл төсөөллөөс давж гарснаар БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийг 2.0 хувь гэж төсөөлж байсан бол энэ долоо хоногт 2.5 хувь болгон нэмэгдүүлээд байна. Тус байгууллага хөрөнгийн захын халалт болон экспортын хязгаарлалтууд сунгагдаж байгаа нь өсөлтөд эрсдэл үүсгэж болзошгүй гэж харж байна. Харин Reuters агентлагийн 42 судлаачдын дунд явуулсан түүвэр судалгааны медиан утгаар БНХАУ-ын эдийн засаг 2.2 хувиар өсөх хүлээлттэй байна.
- **БНХАУ-ын Ардын Банк (ХАБ) 1 жилийн хугацаатай суурь бодлогын хүүгээ 7-р сард хэвээр үлдээв.** Ингэснээр тус хүүгийн түвшин 3 сар дараалан одоогийн 3.85 хувьд хадгалагдаж байна. Ковид-19 цар тахлаас үүдэн дотоод эдийн засагт ирэх дарамтыг саармагжуулах зорилгоор ХАБ бодлогын хүүг энэ жил нийт 0.3 нэгж хувиар бууруулсан бөгөөд дахин 0.4-0.5 нэгж хувиар бууруулах хүлээлттэй байв. Харин 3 дахь сардаа хүүгийн түвшинг хэвээр үлдээснээр ХАБ өмнөх бодлогын арга хэмжээнүүдийн нөлөө санхүүжилтийн өртгийг бууруулж, эдийн засгийн дэмжихийн тулд мөнгөний уян хатан бодлогын хурдацыг бууруулах, цаашид харзнах хүлээлтийг бий болголоо. Үүний зэрэгцээ эдийн засгийн сэргэлт үргэлжилж буй нөлөө, зээлийн тэлэлт зэрэг нь эрх баригчдад дотоод эдийн засгийг эрчимжүүлэх бодлогын хурдацыг сааруулах, бодлогын орон зайг хадгалах боломжийг олгож байна. ХАБ-аас голлон ажиглаж буй самбар<sup>1</sup> дахь 11 индикаторуудын 7 нь 2020 оны 5-р сард нэмэлт дэмжлэг шаардлагатайг илэрхийлж байсан бол 6-р сард тус үзүүлэлтүүдийн тоо 4 хүрч буураад байна. Тэдгээр индикаторуудын заримаас дурдвал:

  - Суурь бодлогын хүү болох 1 жилийн хугацаатай LPR хүү хамгийн сүүлд 4-р сард 0.2 нэгж хувиар буурч, сүүлийн 3 сард 3.85 хувьд хадгалагдаж байна.
  - 5 жилийн хугацаатай LPR хүү буюу орон сууцны зээлийн жишиг хүү 4-р сард 0.1 нэгж хувиар буурснаас хойш 4.65 хувьд хэвээр хадгалагдаж байна.

<sup>1</sup> Dashboard of indicators on PBOC's radar

- Тогтвортой LPRs хүүгийн суурь түвшин буюу 1 жилийн хугацаатай дунд хугацааны зээлийн хэрэгслийн хүү (MLF rate) 4-р сард 0.20 нэгж хувиар буурснаас хойш 2.95 хувьд хэвээр хадгалагдаж байна.
- **БНХАУ-ын Жиангсу мужид болсон үер, 7-р сард орсон их аадар борооны нөлөөгөөр** БНХАУ-ын төв мужууд болон Хубэй мужид ургац алдаж, хэдэн мянган орон сууц сүйдэж, 20 сая гаруй хүмүүс өртөөд байна. Тус үерийн шууд нөлөө нь 64 тэрбум юань буюу 9 тэрбум ам.долларын хор хөнөөлтэй байх тооцооллыг БНХАУ-ын Онцгой байдлын газраас мэдээлэв. Сүүлийн хэдэн арван жилд болоогүй тус үер усны нөлөө 7-р сарын эдийн засгийн үзүүлэлтүүд дээр нөлөөлөхөөр байна. Үл хөдлөх хөрөнгийн нийт хөрөнгө оруулалт (fixed-asset investment growth) 2019 оны 7-р сартай харьцуулахад 3-4 хувиар агших төлөвтэй. Номура байгууллага тус үерээс эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө нь хязгаарлагдмал,

харин ХҮИ-ийг 7, 8-р саруудад 0.6 нэгж хувиар нэмэгдүүлнэ гэж үзэж байна.

- Гахайн махны үнэ өндөр байгаагийн нөлөөгөөр хүнсний инфляц 6-р сард өсөөд байсан хэдий ч гахайн мах, хүнсний ногооны нийлүүлэлт сэргэснээр инфляц эргэн буурах төлөвтэй байна. Гахайн махны үйлдвэрлэл удааширсан, импорт буурсан, цар тахлаас сэргийлэх хатуу арга хэмжээ зэргээс үүдэлтэйгээр гахайн махны үнэ 6-р сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 82 хувиар нэмэгдсэн гэж БНХАУ-ын ҮСХ-ноос мэдээлэв.

#### *Эх сурвалж:*

1. Bloomberg, China React: Loan rate steady, PBOC saves space to ease later
2. Bloomberg, [Flood impact on China's growth to be short-loved, economists say](#)
3. Bloomberg, China Insight: Economic fundamentals signal support for yuan
4. Bloomberg, China Insight: Urgency for PBOC to eases retreats-dashboard
5. Bloomberg, China Commodities Today
6. Bloomberg, [China's Economy Will Grow 2.5% This Year, UBS Says](#)